

**АГУУЛГА**

<b>ОРШИЛ</b> .....	2
<b>НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b> .....	3
Уул технологийн хэсэг .....	4
Ил уурхайн хил хязгаар, түүний хүрээн дэх хүдрийн нөөц .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Уурхайн жилийн хүчин чадал, ашиглах хугацаа.....	5
Уурхайн ажиллах горим.....	5
Ил уурхайн үндсэн хэмжээсүүд .....	5
Хөрс хуулалт .....	5
Овоолгын аж ахуй .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Ашиглалтын систем .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2024 онд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ .....	6
<b>ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУУРЬ СУДАЛГАА</b> .....	7
Уур амьсгалын улирлын ерөнхий горим.....	7
Талбайн геологийн тогтоц .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Ус зүй: .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Хөрсөн бүрхэвч .....	15
Ургамлан нөмрөг .....	15
Амьтны аймаг .....	16
<b>ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ</b> .....	17
<b>ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО</b> .....	17
Эрх зүйн үндэслэл .....	18
<b>ТАВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ</b> .....	19
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө .....	19
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	19
5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	20
5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө: .....	24
5.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө: .....	26
5.4. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө .....	28
5.5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө: .....	28
5.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	30
5.7. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	35
5.8. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (охшх).....	32
5.9. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь: .....	35
6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах үед олон нийтийн оролцоог хангах нь .....	36
7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал .....	36

## ОРШИЛ

“Дацантрейд”ХХК-нь 1996 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд уул уурхайн салбарт тогтмол үйл ажиллагаа явуулсаар ирлээ. Манай компаний Баян-Уулын уурхайн алтны шороон орд нь Хэнтий аймгийн Норовлин сумын нутгийн зүүн урд хэсэгт сумын төвөөс 50 км-т байрлах бөгөөд талбайн төв нь Өндөр хаан хотоос зүүн тийшээ 200км-т Улаанбаатар хотоос зүүн тийшээ 530 км-т тус тус байрлах ба тэдгээртэй шороон замаар холбогдоно.

Уг ордод "Дацантрейд" ХХК 2005-2009 оны хайгуулын ажлын үр дүнгээр нөөц бодож 2010 оны 02 -р сарын 26 –ны өдөр ЭБМЗ –ийн хурлаар алтны бодит В зэргээр 67,25 кг, боломжит С зэргээр 395,16 кг, бүгд 456,69 кг \химийн цэврээр\ нөөцийг улсын нэгдсэн бүртгэлд авсан болно.

Мөн 2011 онд гүйцээх хайгуул хийж ордын нөөцийн зэргийг өсгөсөн ба 2011 оны 12-р сарын 16-ны өдөр ЭБМЗ-ийн хурлаар алтны бодит В зэргээр 389,18 кг/ химийн цэврээр/ нөөцийг улсын нэгдсэн бүртгэлд авсан болно.

Уурхайн эдэлбэр газрын хэмжээ нь 235.15 га ба үүнээс уурхайн зориулалтаар ашиглах талбайн хэмжээ 2.9 га.

2024 онд тус компани нь олборлолтын ажилд хамрагдсан нийт талбайн 50-60 хувьд болон 2022-2023 оны үлдэгдэлтэй нийлээд 3.1 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил, 2023 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн 2.9 га талбайд шимт хөрс тараалтын ажлыг хийнэ гэж төлөвлөгөөнд тусгасан болно. Мөн өмнөх онд техникийн нөхөн сэргээлт хийсэн 2,9 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг тус тус хийхээр төлөвлөсөн.


“Дацантрейд” ХХК нь 2024 оны 04 -р сарын 01-аас 4 -р сарын 15 -н хүртлэх хугацаанд уулын бэлтгэл ажлыг үндсэндээ дуусгаад, биологийн нөхөн сэргээлт, хөрс хуулалтын ажлыг 4-р сарын 15-наас 5-р сарын 20 хүртэлх хугацаанд хийж, элс угаалтын ажлыг 5 -р сарын 10-аас 10 -р сарын 10-н хүртэл хугацаанд, 10 сарын 10-аас 11 сарын 10 хүртэл техникийн нөхөн сэргээлтийн ажлыг гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Хөрс хуулалт- хадгалалт- гадаад овоолго-хөрс зөөвөр-элс гаргалт, зөөлт- баяжуулалт- дотоод овоолго-дүүргэлт-тэгшлэлт-техникийн нөхөн сэргээлт- шимт хөрсөөр хучилт- биологийн нөхөн сэргээлт гэсэн дараалалтай ажиллана.

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

- ТӨСЛИЙН ДУГААР:** 2012/В478
- ТӨСЛИЙН НЭР, АНГИЛАЛ:** Хэнтий аймгийн Норовлин сумын нутаг Уртын хөндийн алтны шороон ордыг ашиглах
- ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН НЭР:** "Дацантрейд" ХХК
- ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:** MV-015599
- АЖ АХУЙН НЭГЖИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУГААР ДУГААР:** 9011094114
- РЕГИСТРИЙН ДУГААР:** 2061848
- ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ:** Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Өөрийн байранд -3Б хэсэг, утас: 99085690, 326025
- ТӨСЛИЙН БАЙРШИЛ** Хэнтий аймгийн Норовлин сумын нутаг дахь Уртын хөндийн алтны шороон орд нь 530 км, Өндөрхаан хотоос зүүн тийш 200 км, Норовлин сумаас зүүн урагш 50 км зайд байрладаг.

№	WGS 1984						UTM	
	Уртраг			Өргөрөг			Уртраг	Өргөрөг
Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд			
MV-015599								
1	112	16	21.79	48	20	23.71	594312.9074	5354864.626
2	112	16	21.86	48	20	10.24	594321.2511	5354448.767
3	112	16	42.13	48	20	10.28	594738.4967	5354456.942
4	112	16	42.12	48	20	22.33	594732.0884	5354828.98
5	112	16	58.02	48	20	22.34	595059.3697	5354834.755
6	112	16	58.02	48	19	46.84	595077.7046	5353738.701
7	112	17	23.02	48	19	46.84	595592.405	5353747.333
8	112	17	23.02	48	19	18.84	595606.9426	5352882.842
9	112	16	47.02	48	19	18.84	594865.6613	5352870.425
10	112	16	47.02	48	19	37.84	594855.8731	5353457.045
11	112	16	21.02	48	19	37.84	594320.5583	5353448.137
12	112	16	21.02	48	19	57.84	594310.3123	5354065.632
13	112	15	36.02	48	19	57.84	593383.9062	5354050.336
14	112	15	36.02	48	20	14.84	593375.2819	5354575.207
15	112	16	2.02	48	20	14.84	593910.4894	5354584.027
16	112	16	2.02	48	20	31.84	593901.8151	5355108.898
17	112	16	58.02	48	20	31.84	595054.4626	5355128.065
18	112	16	58.02	48	20	23.8	595058.6155	5354879.832



Зураг: 1. Ордын байршил



Зураг: 2. Ашигт малтмал ашиглалтын талбайдын ерөнхий байдал

### Уул технологийн хэсэг

Уртын хөндийн алтны шороон орд нь нэгдсэн ангилалаар III бүлэгт хамаарагдах жижиг орд болох ба ихэвчлэн аллювийн хурдас, бул чулуу хоёрын заагт алт агуулагч давхарга нь ус агуулагч үетэй давхцаж байдаг. Хөрс хуулалтын хэсэгт бул чулуу агуулах боловч цэвдэгшил байхгүй, алт агуулагч давхрагын элсний хувьд бул чулуу болон шаваржилт багатай, угаагдах чанар сайтай амархан баяжигдах, алтны мөхлөгийн хэмжээ харьцангуй томтой, уул техникийн нөхцөл сайтайд тооцогдоно. Ашиглалтын үеийн хөрс хуулалтын дундаж зузаан 3,8м, алт агуулагч элсний дундаж зузаан 1,4м, хөрс хуулалтын дундаж коэффициент 2,2 байгаа нь уг орд нь бага гүнд оршиж байгаатай холбоотой бөгөөд олборлолт явуулахад уул техникийн хүндрэл гарахгүй. Мөн ордын талбай нь гидрогеологийн хувьд мөн тааламжтай нөхцөлд оршдог тул ашиглалтын үеийн технологийн усан хангамжид хүндрэл гарахгүй гэж үзлээ. Уртын хөндийн дунд, доод хэсэг нь усаар нилээн элбэг бөгөөд 2,0 м-ээс доош байнгын устай, намагжсан байдалтай

байна. Иймд ордыг ашиглах явцад үйлдвэрийн усан хангамжийг хөрсний усыг тунгаан эргэлтэнд оруулан ашиглах бүрэн боломжтой. Мөн ахуйн усан хангамжийг худагийн усаар хангана.

**Уурхайн жилийн хүчин чадал, ашиглах хугацаа**

2024 онд буюу 5 дахь жилийн уулын ажлын төлөвлөгөөнд тусгаснаар 8-В,7-В блокуудыг ашиглах бөгөөд ашиглалтын явцад 132,4 мян.м<sup>3</sup> хөрс хуулах ба олборлолтын явцад 45,5 мян.м<sup>3</sup> элс угаана. Элсний дундаж агуулга нь 0,59 г/м<sup>3</sup>.

**Уурхайн ажиллах горим**

Элс угаан баяжуулах ажил нь дулааны улиралд хийгдэх шаардлагатай тул элс олборлолтын ажлыг төслийн хугацаанд 5 дугаар сарын 01-аас 10 дугаар сарын 01 хүртэл хугацаанд явуулна.

*Уурхайн ажиллах горим, жилд ажиллах хоног хугацаа*

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Хэмжээ
Уурхайн жилд ажиллах хугацаа	хоног	150
Элс угаах хугацаа	хоног	101
Бэлтгэл ажил хийх хугацаа	хоног	30
Хөрс хуулалт хийх хугацаа	хоног	14
Баяр ёслолын өдрүүд	хоног	10
Урсгал засвар хийх өдрүүд	хоног	5
Уурхайг хаах хугацаа	хоног	10
Ажиллах ээлжийн тоо	ээлж	2
Ээлжийн цэвэр ажиллах хугацаа	цаг	12

**Ил уурхайн үндсэн хэмжээсүүд**

Хөрс хуулалт болон элс олборлолтын ажилд буюу ил уурхайн ажиллах техник тоног төхөөрөмжөөс шалтгаалуулан ил уурхайн үндсэн хэмжигдэхүүнийг дараах байдлаар сонгосон байна.

*Уурхайн үндсэн хэмжигдэхүүнүүд*

№	Хэмжигдэхүүнүүд	Хэмжээ
1	Ажлын доголын өндөр	5.0м
2	Доголын өргөн	7.0м
3	Доголын налууугийн өнцөг	55°
4	Траншейн налуу	70%
5	Ажлын талбайн өргөн	9.5м

**Хөрс хуулалт**

*Уурхайн хөрс хуулалтын хэмжээ*

Ашиглалтын жилүүд	Шимт хөрс хуулах талбайн хэмжээ, мян.м <sup>2</sup>	Шимт хөрс байрлуулах талбайн хэмжээ, мян.м <sup>2</sup>	Шимт хөрсний хэмжээ, мян.м <sup>3</sup>	Дотоод овоолгод тээвэрлэх хөрсний хэмжээ, мян.м <sup>3</sup>	Гадаад овоолгод тээвэрлэх хөрсний хэмжээ, мян.м <sup>3</sup>
5 дахь	29.0	0,8	23,2	58,4	38,9

### Уулын үндсэн техникүүдийн хүчин чадал, хэрэгцээний тооцоо

Ордыг ашиглахад доорх техник хэрэгслэлийг ашиглах болно. Үүнд:

Бульдозер CAT D5	- 1 ш
Бульдозер SD-23	- 1 ш
Бульдозер SD-16	- 1 ш
Экскватор –CAT-320	- 1 ш
Экскватор –300L	- 1 ш
Экскватор –SE210	- 1 ш
Экскватор –SE370	- 1 ш
Скруббер KBW-5745	- 1 ш
Насос /хятад/	- 4 ш

### Овоолгын аж ахуй

Үржил шимт хөрс буюу 0.2-0.4 м-ийн зузаан өнгөн хэсгийг уурхайн төвөөс 2 тийш бульдозероор түрж, уурхайн хилийн гадна талбайд далан маягаар овоолж байрлуулна.

### Ашиглалтын систем

Ордын уул геологийн нөхцөл, одоо ашиглаж буй уурхайн тоног төхөөрөмж, тэдгээрийн хүчин чадал зэргийг харгалзан үзэж уурхайн өнөөгийн дотоод овоолго бүхий ашиглалтын системийг үргэлжлүүлэн ашиглах боломжтой гэж үзлээ.

Элс баяжуулах ажилд “KBW” маркийн скруббер ашигласнаар элс болон хөрсийг богино зайд тээвэрлэж, уурхайн ашигласан орон зайг дотоод овоолгоор дүүргэж, техникийн нөхөн сэргээлтийг нэгэн зэрэг хийх юм. Энэ нь уурхайн нөхөн сэргээлтийн ажлыг богино хугацаанд хийх нөхцлийг бүрдүүлж байна.

Уртын хөндийн ордын ашиглалтын үндсэн процессууд:

- Үржил шимт өнгөн хөрс хуулалтын ажил
- Хөрс хуулалтын ажил
- Элс олборлолтын ажил
- Элс баяжуулалтын ажил
- Хөрсний овоолгын тэгшлэлтийн ажил
- Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил

### 2024 онд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ

Энэхүү 2024 онд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд өртөх нийт талбай 2,9 га талбайн газрын хурдас эвдрэлд орно.

Мөн энэ онд уулын ажлын төлөвлөгөөгөөр уурхайн хэмжээнд 132,4 мян.м<sup>3</sup> хөрс хуулах ба үүнээс 132400 м<sup>3</sup> нь шимт хөрс болно.

Уурхайн үйл ажиллагаанд өртөх талбайн шимт хөрсийг 0.1-0.4м-ын зузаантайгаар хуулж, Монгол Улсын MNS 5917:2008 зааврын дагуу олборлолтын дараах нөхөн сэргээлт хийхэд өнгөн бүрхүүлийг хучих материал болгон ашиглахад зориулан хөрсний овоолгоос тусад нь тусгайлан байршуулна.

2024 онд нийт 132,4 мян.м<sup>3</sup> хөрс хуулах бөгөөд үүний 30%-ийг өмнө ухсан хоосон орон зайд, 50- 60%-ийг дотоод овоолгод байршуулахаар төлөвлөж байна.

## ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН СУУРЬ СУДАЛГАА


### Уур амьсгалын улирлын ерөнхий горим

Монгол орны газар нутаг гадаад далай тэнгисээс ихээхэн алслагдсан, Евразийн эх газрын төвд тал бүрээсээ өндөр уул нуруугаар хүрээлэгдсэн, далайн түвшнээс дунджаар километр хагас илүү өндөр өргөгдсөн зэргээс шалтгаалан эх газрын эрс тэс, хатуу ширүүн уур амьсгалтай.

Монгол орны уур амьсгалын гол онцлог бол жилийн дөрвөн улирлын ялгаа ихтэй, энэ чанараараа агаарын температурын хэлбэлзэл өндөр, хур тунадас бага, уур амьсгалд өргөрөгийн болон өндрийн бүслүүрийн ялгаа тодорхой илэрдэг явдал юм. Монголд богино (VI сараас VIII сарын дунд хүртэл үргэлжлэх), хуурай зун, ихээхэн хүйтэн, урт (XI сараас IV сар хүртэл үргэлжлэх) өвөлтэй, хавар намрын улирлын үргэлжлэх хугацаа жилээс жилд өргөн хүрээнд хэлбэлздэг онцлогтой.

### Агаарын дулаан, хүйтэн

Өвлийн улирлын дундаж температур  $-15^{\circ}\text{C}$ ... $-30^{\circ}\text{C}$  ( $6^{\circ}\text{F}$ ... $22^{\circ}\text{F}$ ), зуны улирлынх нь  $10^{\circ}\text{C}$ ... $26.7^{\circ}\text{C}$  ( $50^{\circ}\text{F}$ ... $80^{\circ}\text{F}$ ) байна. Жилийн дундаж агаарын температур Алтай, Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулархаг нутгаар  $-4^{\circ}\text{C}$ -аас хүйтэн, үүний дотор уулс хоорондын хотгор, томоохон голын хөндийгөөр  $-6$  -  $-8^{\circ}\text{C}$  хүйтэн, цөлөрхөг хээрийн бүсэнд  $2^{\circ}\text{C}$ -ээс дулаан, өмнөд говьд  $6^{\circ}\text{C}$ -аас дулаан байна (Зураг 1). Агаарын жилийн дундаж температурын  $0^{\circ}\text{C}$ -ын шугам нь Монгол орны цөлөрхөг хээрийн, /говийн/ бүсийн хойд хилээр дунджаар хойд өргөрөгийн  $46^{\circ}$ -ийн дагуу байна. Агаарын жилийн дундаж температур  $-2^{\circ}\text{C}$ -аас хүйтэн нутагт мөнх цэвдэгт хөрс тархсан байдаг.




*Жилийн дундаж агаарын температурын газарзүйн тархац /Нацагдорж, Цэвэлсүрэн 2000/*

Жилийн хамгийн хүйтэн 1 дүгээр сарын дундаж температур Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулс хоорондын хөндийд  $-30$ ... $-34^{\circ}\text{C}$ , өндөр уулс, тэдгээрийн хоорондох хөндийгөөр  $-25$ ... $-30^{\circ}\text{C}$ , талархаг нутагтаа  $-20$ ... $-25^{\circ}\text{C}$ , говь цөлийн бүсээр  $-15$ ... $-20^{\circ}\text{C}$  өмнөд говиор  $-15^{\circ}\text{C}$ -аас  $-12^{\circ}\text{C}$  хүйтэн байдаг (Зураг 2). 1940-өөд оноос хойш хийсэн цаг уурын хэмжилтийн мэдээгээр агаарын үнэмлэхүй бага температур  $-55.3^{\circ}\text{C}$  /1976 оны 12 дугаар сард Увс аймгийн Зүүнговь суманд/ хүрч байсан бол нийслэл Улаанбаатарт  $-49.0^{\circ}\text{C}$  хүрч /1954 оны XII сард/ байжээ.. Жилийн хүйтэн улирлын температурын горимд инверсийн нөлөө их.


Тэгш тал хээр газарт газрын гадаргаас дээшлэх тутам агаарын дундаж температур буурдаг зүй тогтолтой бол зарим газар температур өндрөөсөө нэмэгдэхийг инверсийн

үзэгдэл гэдэг. Томоохон голуудын хөндийд байрладаг аэрологийн станцуудын мэдээгээр жилийн хүйтэн улиралд бараг өдөр бүр шахам 600-1000 м орчим зузаантай 6-17<sup>0</sup>С-ийн эрчимтэй газар орчмын температурын инверс тогтоно. Үүнээс болж голын хөндий, хотгор газарт 100 м өндөрсөх тутам агаарын температур 0.8-0.9<sup>0</sup>С-аар, уулын хажуу, тал газарт 0.6<sup>0</sup>С-аар дулаарна.



Өвлийн улирлын дундаж температурын газарзүйн тархац

Жилийн хамгийн дулаан 7 дугаар сарын дундаж агаарын температур Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулсаар 15<sup>0</sup>С-аас сэрүүн, үүний дотор өндөр уулын ян сарьдагаар 10<sup>0</sup>С-аас сэрүүн, Их нууруудын хотгор болоод Алтай, Хангай, Хэнтийн уулсын завсар нутаг, Орхон Сэлэнгийн болон Халх голын саваар 15...20<sup>0</sup>С, Дорнодын талын өмнөд хэсэг, говь цөлийн бүсэнд 20...25<sup>0</sup>С, үүний дотор өмнөд говь, Дорноговийн хотгороор 25<sup>0</sup>С-аас дулаан байна. (Зураг 3)



Зуны улирлын дундаж агаарын температурын газарзүйн тархац /Нацагдорж, Цэвэлсүрэн 2000/

Жилийн дулаан улиралд агаарын температурын өндрөөшөө буурах ердийн хувиарлалт тогтоно. Өөрөөр хэлбэл 100 м өгсөхөд температур 0.5-0.6<sup>0</sup>С-аар буурна. Уулархаг нутагт хаврын сүүлчийн цочир хүйтрэл хожуу /6 дугаар сарын дундуур/ дуусч, намрын эхний цочир хүйтрэл эрт /8 дугаар сарын сүүлчийн арав хоногт/ эхлэх тул хүйтрэлгүй үеийн үргэлжлэх хугацаа 70 хоногоос цөөн, бусад нутагтаа 90-130 хоног байна.


Ургамлын дулаан хангамжийн үүднээс хоногийн дундаж агаарын температур 10<sup>0</sup>С-аас их байх хугацаа болон энэ хугацаанд хуримтлах дулааны нийлбэр ихээхэн ач холбогдолтой. Хоногийн дундаж агаарын температур 10<sup>0</sup>С-аас дээш байх хугацаа манай



орны өндөр уулын бүсэнд буюу далайн түвшнээс 2000 м ба үүнээс дээш өргөгдсөн нутагт 90 хоног буюу үүнээс цөөн, ойт хээрийн бүсэд 90-110 хоног, хээрийн бүсэнд 110-130 хоног, цөлөрхөг хээрийн бүсэд 130-150 хоног, цөлийн бүсэд 150 хоногоос дээш байна.

Хур тунадас


Монгол оронд хур тунадас ерөнхийдөө бага ордог, Хангайн нуруу, Хөвсгөл, Хэнтэйн уулсаар 300-400 мм, Монгол Алтайн болон ойт хээрийн бүсэнд 250-300 мм, хээрийн бүсэнд 150-250 мм, говь цөлийн бүсэнд 150-50 мм орчим хур тунадас унана. Хур тунадас хойноос урагш, зүүнээс баруун тийшлэх тутам буурах авч түүний хуваарилалтанд газрын хотгор гүдгэрийн нөлөө их.



*Жилийн нийлбэр хур тунадасны газарзүйн тархац /Нацагдорж, Цэвэлсүрэн 2000/*

Монгол оронд ордог хур тунадасны хэмжээ хөрсний ууршиц /ууршуулах чадвар буюу ууршуулах хэрэгцээ ч гэж ярьдаг/-аас олон дахин бага, өөрөөр хэлбэл нийтдээ чийг дутмаг. Ууршлын хэмжээ өндөр уулын бүслүүрт 500 мм-ээс бага, ойт хээрийн бүсэнд 550-700 мм, хээрийн бүсэнд 650-750 мм, цөлөрхөг хээр, цөлийн бүсэнд 800-1000 мм байдаг.

Хур тунадасны 85% орчим нь жилийн дулаан улиралд /IV-IX сард/ үүнээс зөвхөн 7,8 дугаар сард 50-60% нь орно.




*Зуны хур борооны хэмжээний газарзүйн тархац /Нацагдорж, Цэвэлсүрэн 2000/*

Хэдийгээр хур тунадас бага боловч түүний нэгж хугацаанд орох эрчим их. Дөчөөд оноос хойш хийсэн цаг уурын хэмжилтээр нэг хоногт орсон хамгийн их хур тунадас Даланзадгадад 138 мм /1956 оны 8 дугаар сарын 5-нд/, Сайншандад 121 мм /1976 оны 7 дугаар сарын 11/ хүрч байсан ба 1 цаг хүрэхгүй шахам хугацаанд 40-65 мм хур буух тохиолдол хаана ч тохиолдож мэднэ. Монгол оронд нутгийн хойд уулархаг хэсгээр 60-70 өдөр, Хангай, Хэнтийн нурууны захын бэсрэг уулс, уулс хоорондын хөндий,

Дорнодын талаар 40-60 хоног, говьд 30 орчим өдөр бороотой байх боловч жилийн хур тунадасны ихэнх нь цөөхөн хэдэн борооноос бүрэлддэг онцлогтой. Өөрөөр хэлбэл Монгол оронд хур тунадасны нийт хэмжээ бага боловч хур тунадасны эрчим ихтэй, аль ч нутагт хоногт 50 мм-ээс их бороо ажиглагддаг боломжтой.

Жилийн хүйтэн улиралд /XI-III сард/ говь цөлийн бүсэд 10 мм орчим, уулархаг орон нутаг, Увс нуурын хотгорт 20-30 мм, бусад нутагт 10-20 мм цас орох бөгөөд /Зураг 5б/



Өвлийн улиралд ордог цасны хэмжээний газарзүйн тархац /Нацагдорж, Цэвэлсүрэн 2000/

Монгол Алтай, Хангай, Хэнтий, Хөвсгөлийн уулсаар 150 хоногоос дээш, хээрийн болон ойт хээрийн бүсэд 100-150 хоног, Их нууруудын хотгор, Дорнод Монголын тал, хээрийн бүсэд 50-100 хоног, говь цөлийн бүсэд 50 хоногоос цөөн хоног цасан бүрхүүл тогтоно. Цасан бүрхүүлийн зузаан их биш уулархаг нутагт дунджаар 5 см, хамгийн зузаан цасны дундаж 30 см-ээс их, хээрийн бүсэд дунджаар 2-5 см, хамгийн их цасны дундаж зузаан 15-20 см байна. Говийн бүсэд цас тогтохгүй жил элбэг.


#### Нарны гийгүүлэл

Монгол оронд үүлшил бага, цэлмэг өдрийн тоо их, жилдээ 230-260 хоног байх тул жилдээ 2600-3300 цаг нар гийгүүлнэ.

#### Салхи шуурга

Монголын тал хээр, говь цөлийн бүс салхи ихтэй. Жилийн дундаж салхины хурд энэ бүс нутагт 4-6 м/с. Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгийн уулс хоорондын хөндийд 1-2 м/с, бусад нутгаар 2-3 м/с орчим байдаг. Тус орны 250 хот суурин орчимд хийсэн цаг уурын хэмжилтийн мэдээгээр нутгийн дөрөвний нэг орчимд нь жилийн дундаж салхины хурд 4.0 м/с-ээс их. Ихэнхдээ баруун, баруун хойд, хойд зүгийн салхи зонхилох боловч газрын хотгор гүдгэрийн нөлөөгөөр орон нутгийн ялангуяа уул-хөндийн салхи элбэг тохиолдоно.

Монгол орны нутгийн 41.3%-ийг эзлэх говь-цөлийн бүсэнд сул шороо элбэг, салхи ихтэй тул шороон шуурга олонтоо тохиолдоно. Энэ бүс нутагт жилдээ 30-100 өдөр, Монгол элсний өмнөд захад жилдээ 120 өдөр шороо хийснэ.



*Жилд шороо хийсдэг өдрийн тооны газарзүйн тархац /Natsagdorj, Jugder, Chunhg/*

Шороон шуургатай өдрийн тооны 61% нь хаврын гурван сард, 7% нь зуны улиралд, хоёрдогч их утга нь намар, хоёрдогч бага утга нь өвлийн улиралд тохиолдоно. Гэхдээ энэ нь нутаг дэвсгэрээр ялгаатай, Увс нуурын хотгорт өвөл огт шороо хийсдэггүй атал Арцын өвөр хоолойд өвлийн гурван сард нийт шороон шуургатай өдрийн тооны гуравны нэг ногдоно. Шороон шуурганы 80% нь өдрийн гэрэлтэй цагт тохиолдоно. Олон жилийн ажиглалтаар Монголын говь цөлийн бүсэнд жилдээ 300-600 цаг шороо хийсдэг ажээ. Монголын шороон шуурга бол зүүн Азийн “шар тоос”-ны нэг гол эх үүсвэр юм. Эхийг MARCC-2009-өөс (<http://www.climatechange.mn>) авсан болно.

Хэнтий аймгийн уур амьсгалын өөрчлөлт

Хэнтий аймгийн нутаг эх газрын уур амьсгалын их мужид багтах бөгөөд эх газрын эрс тэс уур амьсгалтай. Уур амьсгал нь адил өргөрөгт орших бусад нутгаас нилээд онцлогтой. Байгалийн бүс, бүслүүрийн хувьд олон бүсэд хамаарагддаг. Тиймээс уур амьсгалын өөрчлөлт бүс бүрд өөр өөр давтамж, хэмжээгээр илэрдэг төдийгүй үзүүлэх нөлөөлөл нь янз бүр байдаг. Иймээс тухайн орон нутаг бүр уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицаж амьдарч сурахын тулд өөрчлөгдөж буй хүчин зүйлсийн учир шалтгааныг мэдэж байх нь туйлын чухал юм.

Судалгаанд ашигласан материал

Хэнтий аймгийн Өндөрхаан өртөөний 1955-2009 оны, Биндэр өртөөний 1961-2009 оны уур амьсгал болон хөдөө аж ахуйн цаг уурын ажиглалтын материал, 2006-2009 онуудад хийсэн албаны инженер техникчидийн судалгааны ажлын материалуудыг ашиглав.

Агаарын дундаж температур ойт хээрийн бүсэд 2000 оноос тал хээрийн бүсэд 1990 оноос 1-2 градусаар дулаарч эхэлжээ. 1975-1984 онууд олон жилийн дунджаас сэрүүн жил байжээ.



Агаарын дундаж температурын олон жилийн өөрчлөлт

Олон жилийн дундажаар Хэнтий аймгийн агаарын үнэмлэхүй их, бага температурын дунджийн агууриг 15,5 градус байна. Ойт хээрийн бүсэд 2000 оноос 1 градус, тал хээрийн бүсэд 1990 оноос агаарын температурын агууриг 0,5-2,0 градусаар нэмэгдсэн байна. Дулааны улиралд температурын агууриг илүү нэмэгдсэн байна.




Жилийн температурын олон жилийн нормчилсон хазайлт

Дулааны улирлын тунадасны хэмжээ 24,5 %-аар буурч, хүйтний улирлын тунадасны хэмжээ 39,5 %-аар нэмэгджээ. Улирлаар авч үзвэл зуны тунадас 25,3%-аар буурч, өвлийн тунадас 32,7 хувиар нэмэгдсэн бол хаврын тунадас буурсан үед намрын тунадас өссөн гэх мэт харилцан уялдаатайгаар хэлбэлзсэн байна.



Улирлын хур тунадасны хэмжээ, мм

Сүүлийн жилүүдэд хур тунадасны шинж ихээхэн өөрчлөгдсөн. 1974-1983 онд зүс тунадас 43%, аадар тунадас 57% байсан бол 1994-2003 оны үед дээрх харьцаа 13% ба 87% болж өөрчлөгдсөн байна. /Л.Ганчимэг, М.Сарнайцэцэг. 2005 он/




Хур тунадасны хуваарилагдалтыг авч үзвэл 5 сарын 2 арав хоногоос 6 сарын 1 арав хоног хүртэл, 7 сарын 2 арав хоногоос 8 сарын 2 арав хоног хүртэл хур тунадасны хэмжээ буурсан байна.




Хур тунадасны жилийн тархалт

1975-1994 онуудад хүчтэй салхи 4 сард хамгийн их утга ажиглагддаг байсан бол 1995 оноос хойш хүчтэй салхитай өдрийн тоо 20%-аар нэмэгдэн хамгийн их утга нь 5 сард ажиглагдсан байна.




15 /с-ээс дээш салхитай өдрийн олон жилийн явц

Хэнтий аймгийн нийт уст цэгийн тоо 2003 онд 49,8 %-аар, 2007 онд 67%-аар цөөрч, булгийн ундарга 2 дахин буурсан. Томоохон голуудын урсацын хувьд 1995 оноос хойш татруу жилүүд үргэлжилж байна



Хэнтий аймгийн уст цэгийн харьцуулалт

Бэлчээрийн ургацын хэмжээ 2007 онд аль ч бүсэд хамгийн бага ургацтай байсан бол ойт хээрийн бүсэд 2009 он, хээр болон цөлөрхөг хээрийн бүсэд 2003 он хамгийн их ургацтай жил байжээ. Бүрхэцийн хувьд хээрийн бүсийн хувьд өөрчлөлт бага, ойт хээр болон цөлөрхөг хээрийн бүсэд ногоон ургамлын хэмжээ буурчээ.



Бэлчээрийн ургацын хэмжээ

Талбайн геологийн тогтоц

Судалгааны талбайд 1: 200 000 масштабтай эрэл зураглалын ажил хийгдсэн ба геологийн тогтоцын хувьд нийлмэл бөгөөд Хэнтийн салбар уулсын зүүн хэсгээр байрладаг. Монгол Өвөр байгалийн структур –формацийн бүс, Төв Монголын атираат системд хамаарагдана. Тус

талбайд палезойгоос эхлээд Дөрөвдөгч хүртэл янз бүрийн насны, янз бүрийн найрлагатай тунамал, вулканоген, интрузив чулуулгууд тархсан маш нийлмэл геологийн тогтоцтой.

### Ус зүй

Судалгааны талбай дотор урсаж байгаа голууд байхгүй бөгөөд урсдаггүй голын хөндийнүүд байна. Эдгээр нь ихэнхдээ V хэлбэртэй бөгөөд эх рүүгээ нарийхан, адаг руугаа өргөссөн байх бөгөөд уулнаасаа эх авна. Судалгааны талбайд цэнгэг, ундны устай нилээд хэдэн булаг, худаг байдаг. Үүнд: Өгөөмөрийн худаг, Уртын булаг, Өлзийт булаг зэрэг юм.

### Хөрсөн бүрхэвч

Энэ нутаг нь хөрс-газарзүйн мужлалтаар Хангайн мужийн өндрийн бүсшилийн Хангай-Хэнтийн дэд мужийн 54-р тойрогт багтана.

Уулын хоорондох хөндий, уул толгодын налуу хажууд хар хүрэн хөрс голлохын хамт ам хөндийн ёроолд нь нугат-хүрэн, нугат-хар шороон, нугат-намгийн хөрстэй байна.

Хөрс ихэнхидээ хөнгөн элсэнцэр бүрэлдэхүүнтэй байгаа нь эвдрэлд хялбархан нэрвэгдэж, үржил шимээ түргэн алдах нөхцөлтэй.

Энэ тойрог хээрийн бүсийн бусад нутагтай харьцуулахад илүү чийглэг шинжтэй, хур тундас арай илүүтэй унадаг учир ургамлын ургац харьцангуй сайн өтгөн, өндөр ургасан байна.

Ургамлан бүрхэвчид алаг өвс-үетэн-агьт хээр зонхилж хялгана, биелэг өвс ихтэй, агь, дааган сүүл, хазаар өвс бүхий ургамлын бүрхэц 60-70% хүрнэ.

Хөрсний хими-физик шинж: Ашиглалтын талбайн хөрсөнд хийсэн задлан шинжилгээний дүнгээс харахад ашиглалтын талбайн хэмжээнд тархсан хөрс нь хөрс үүсгэгч эх чулуулгийн төрөл, тэдгээрийн илрэх гүн, ул хөрсний усны тэжээлийн нөхцлөөс хамаарч харилцан адилгүй шинж чанартай байна. Тухайлвал хөрсний дээд А давхаргад ялзмагийн хэмжээ ялзмаг ихтэй хар шороон хөрсөнд 8,71%, нугат-намгийн бүдүүн ялзмагт глейт хөрсөнд 15,05% задарч амжаагүй органик бодис ихтэй, далд глейрхэг хар шорон хөрсөнд 7,44%, ердийн хар хөрсөнд 3,52-3,69% -д хэлбэлзэж харилцан адилгүй хэмжээтэй байна.

### Ургамлан нөмрөг

Норовлин сум ойт хээр, хээрийн бүсэд байрладаг бөгөөд 533.3 мянган гектор нутагтай, нутгийн умард цэг Онон голоос өмнөд цэг Шилийн холбоо хүртэл 120км, өрнөд цэг Цогт-Өндөрөөс /дэлгэр булгийн давааны/ дорнод цэг бага Онцгой уулын орой хүртэл 70 орчим км ,хойноос өмнө зүгт сунасан өргөн уудам нутагтай .Бүх нутгийн ихэнх хэсгийг ойт хээр ,бусдыг нь тал хээр ,ухаа гүвээ толгод эзэлдэг.

Нийт нутгийн өндөр цэг сумын төвөөс баруун өмнө 35 км орчимд буй Хаядэлгэр хаан уул 1594.3м, хойно орших Бүрэн хаан уул 1554.0м, зүүн урд байрлах Түмэн хаан уул 1357.0м,Норовлин Баян уул сумын заагт орших Дун хаан уул 1534.7м болон хойт хэсэгтээ Хэнтийн нурууны салбар уулс болох Эрээн давааны нурууны зэрэг ой модот уулстай.

Сумын хамгийн нам дор газар нь сумын төвөөс зүүн тийш 30 км -т Улзын голын дагуу 950 м орчим өргөгджээ .Сумын нутаг нь далайн төвшингөөс дунджаар 1200 м өргөгдсөн, Нутаг дэвсгэрт жилдээ 220-230 мм орчим тунадас унаж, хөрсний 60 орчим

хувь нь борооны, 40 орчим хувь цасны чийгээр тэжээгддэг учир ган зуд тохиох нь харьцангуй цөөн.

Хүйтний дээд хэмжээ нь 39 хэм гаруй, дулааны дээд хэмжээний 37хэмээс төдийлөн хэтэрдэггүй. Салхины чиглэл голдуу баруун хойноосоо, өвлийн улиралд баруун өмнөдөөс голлодог. Хамгийн их салхи хавсаргатай үе 3,4,5-р сар үе үе 14-20м/сек хүрч ширүүсдэг боловч ихэнхдээ тогтуун нарлаг байдаг. Уулын чулуулаг, намгархаг, хээрийн шороон хөрсний давхаргатай, уул даваа олонтой. Шивэрийн даваа, Улаанхамар, Их даваа, Сонор, Цагаан даваа, Ар, Өвөр Орной, Хуцын хоолой, Уртын хөндий, Хулстай, Хонгор, Ангиртын тал гэх мэт олон тал хөндийтэй.

Онон, Улз, Орной Хөндий, Дарцагт, Урт, Бэрх Баянгол, Могой Мэхээрч, Хуцын Гол, Алтан эмээл, Цагаан чулууут, Шивэр, Хөндлөн, Баянбулаг, Замт зэрэг гол мөрөн горхинуудтай боловч ихэнх нь ширгэж байна.

Мөн Улзын Цагаан нуур, Түмэнхааны Цагаан нуур, Хулстай, Ангирт Бул нуур далтын Цагаан нуур, Улзын Хулстай, Харчулуут, Хар нуур, Цэгээний нуур гэх мэтийн олон нууруудтай боловч зарим нь ширгэж байгаа нь байгаль экологийн тэнцвэр алдагдаж байгааг харуулж байна. Тогоот, Замт, Улаалзаргана зэрэг рашаан булаг шандтай. Шилмүүст навчит ойтой. Үүнд шинэс, нарс, хус, улиас, бургас зэрэг модтой бэлчээрийн төрөл бүрийн ургамалтай.

#### Амьтны аймаг

Хэнтий аймгийн Норовлин сумын нутагт орших Уртын хөндийн орд газар нь амьтны газарзүйн мужлалын хувьд Хэнтийн тойрогт багтана. (А.Г.Банников, 1954)

Нийт талбайд тарвага, зурам, чандага, туулай, үнэг, хярс, дорго, чоно, гөрөөс, мэрэгчид ба махчин амьтад амьдардаг. Жигүүртнээс шаазгай, хар хэрээ, цахлай болон бусад төрлийн шувууд байдаг.



## ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү төслийн БОНБНҮнэлгээний тайлангаас үзэхэд “Дацантрейд” ХХК-ийн “Уртын хөндийн алтны шороон ордыг ашиглах төслийн үйл ажиллагааны үед сөрөг нөлөөлөлд хамгийн хүчтэй өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг нь газар, хөрс, агаар болон газрын доорхи ус, байгалийн бэлчээр, ургамалд үзүүлэх нөлөөллүүд голлох нөлөөлөлд хамаарч байна. Уулын үйлдвэрлэл явуулснаар тухайн нутгын биосферт нөлөөлж болохуйц процесс, тэдгээрийн үр дагаврыг дараах гол сөрөг нөлөөллийн хүснэгтгээр харуулсан болно.

*Гол сөрөг нөлөөлөл*

Биосферийн элементүүд	Биосферийн элементүүдэд уулын үйлдвэрлэлийн үзүүлэх нөлөөлөл	Гарч болзошгүй үр дагавар
Хөрс	Овоолго, зам харилцаа, түр зуурын барилга байгууламж, тунгаагуур ба усан сан, шороон боомт барих	Газрын гадаргуугийн деформаци, хөрсний элэгдэл, угсралт, талбайн бүх төрлийн өөрчлөлт
Усан орчин	Ус таталт, тунгаагуур, усан сангийн бохирдсон ус	Усны нөөцийн горимын өөрчлөлт, урсгал ба гүний усны бохирдол
Агаарын орон зай	Агаарын тоосжилт, хорт хийн тархалт	Агаарын бохирдолт

## ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО

“Дацантрейд” ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийн үр дагаварыг тогтмол хянах, илрүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтэд нутгийн иргэдийн оролцоог хангах, нэмэгдүүлэх зорилт тавьдаг. Бид уурхайн үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш жил бүр төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлж, Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг бүрэн амжилттай хэрэгжүүлсээр ирсэн.

2024 оны төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавьсан.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, 2014 онд Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах зөвлөмж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгосон. Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж байх болно.

Бид 2024 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд дараахи гол зорилтуудыг тавьж ажиллана. Үүнд:

- Компанийн нийт ажилчдын байгаль орчны соёлыг өөрчлөх, экологийн мэдлэгийг дээшлүүлэх, тэднийг байгаль хамгаалах үйлст татан оролцуулах, компанийн байгаль орчны бодлого, хууль эрхзүйн дүрэм журмуудыг танилцуулах, нийт ажилчдыг хамарсан байгаль орчны сургалт, мэдлэг олгох зорилготой байгаль орчинд ээлтэй эко-уурхай болох зорилго тавьж ажиллана.
- Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг сайжруулж, түүнд нутгийн иргэдийг оролцоог хангах, дэмжих ажлыг үргэлжүүлэн хийнэ.
- Уурхайн усны менежментийг сайжруулж, хог хаягдлын хэмжээ, түүний байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор шат дараатай арга хэмжээ хэрэгжүүлж, дахин ашиглах боломжтой хог хаягдлыг дахивар дахин боловсруулах зах зээлд нийлүүлэх хувь хэмжээг нэмэгдүүлнэ.
- Үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчин болон эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц үр дагаврын тухайн нутгийн иргэдээс мэдээлэл өгөх явдлыг урамшуулж ажиллана.
- Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, нөхөн сэргээлтийн ажилд нутгийн ургамлын үрийг ашиглана.
- Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг шат дараатай авна.

### Эрх зүйн үндэслэл

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Энэхүү төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг хангахдаа байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайланд тусгагдсан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг үндэслэн байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ тэдгээрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавьсан.

Мөн Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хуулийн 31.4 дэх заалт болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 9.6, 9.7 дахь заалт, 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянах, батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний

дүгнэлт, мөн нарийвчилсан үнэлгээний үр дүн, 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг шалгасан ажлын хэсгийн дүгнэлтээс гарсан зөвлөмж зэргийг удирдлага болгов.

Бид төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлс хийх, урьдчилан сэргийлэх, бууруулах, нөлөөллийг байж болох хамгийн бага хэмжээнд байлгах бөгөөд байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг хангаж, явцад нь хяналт тавин ажиллах болно.

### ТАВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хүний нөөц, байгаль орчны удирдлагын бүтэц зохион байгуулалтын схемийн хамт дараахи чиглэлээр боловсрууллаа. Үүнд:

1. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө
2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийтэд тайлагнах төлөвлөгөө,
3. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр хийх ажлуудыг тусгалаа.

#### Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Энэхүү Уртын хөндийн алтны шороон ордыг ашиглах төслийн үйл ажиллагааны үед мөрдөх байгаль хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэгч нь “Дацантрейд” ХХК байна.

Төлөвлөгөөний хэрэгжилтэд “Байгаль орчныг хамгаалах тухай”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай”, “Усны тухай”, “Газрын тухай зэрэг хууль тогтоомжинд заасны дагуу төрийн захиргааны төв орон нутгийн байгууллагууд хяналт тавьж хэрэгжилтийг хангуулна.

#### Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийн болон үр дагаврын тархалтын хүрээний нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн, үзүүлэлтүүдийг тодорхойлох, дээж, сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, шинжилгээ хийх давтамж, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон, тусгасан болно.

5.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
<b>АГААР МАНДАЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ</b>						
Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Хүнд механизмын утааны хэмжээг стандартын шаардлага хэмжээнд байлгах талаар хөдөлгүүрийн тохиргоо үйлчилгээг тогтмолжуулах	- Ажиллах нийт хугацаанд; - Бүх хүнд механизм;	0.75	0.75	2-3 улиралд	Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага MNS 4585 : 2007
	Уурхайн карьер, овоолгод ажиллаж байгаа машин техникийн кабин доторхи агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч байх;	- Ажиллах нийт хугацаанд; - Бүх хүнд механизм;	ҮАЗ-д	ҮАЗ-д	2-3-р улиралд	ХАБЭАТ хууль Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
Дүн				0.75		

УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРИЛГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ						
Ашиглалтын улмаас газар доорхи усны түвшин буурах	Сав газартай ус ашиглах гэрээ байгуулан ажиллах	- Төслийн хэмжээнд	ҮАЗ-д	ҮАЗ-д	Уулын ажил эхлэхийн өмнө	“Усны тухай хууль”-28,4-р
	Унд ахуйн ус ашиглаж байгаа хэсгийг бохирдлоос сэргийлж цэвэрлэгээ арчилгааг тогтмол хийж, тэмдэгжүүлэх	- Төслийн хэмжээнд	1.64	1.64	Төслийн хугацааны турш	Ундны усыг бохирдлоос хамгаалах журам 143/А/352
	Уурхайн дээд болон доод хэсэгт байгуулсан газар доорх усны хяналтын мониторингийн 2 ширхэг цооногийн хэмжилт дээжлэлтийг хийж байх	- Уурхайн (хөндийн) дээд болон доод талд	ҮАЗ-д	ҮАЗ-д	3-р улиралд	MNS5667-10:2001
	Уртын булагийн эхийг хамгаалах, хаалт, хашилтийг жил бүр засч сайжруулах	Төслийн хүрээнд	ДХ зардалд туссанаар		3-р улиралд	MNS 4586-98
	Тус уурхай нь үйлдвэрлэлд ашиглагддаг шүүрлийн усыг тунаах нууруудаар эргэлдүүлэн цэвэршүүлж дахин үйлдвэрлэлд ашигладаг /ТЭЗҮ-ийн дагуу/ бөгөөд тунаах нуурууд болон цэвэр уснаас жилд 2 удаа стандартын дагуу шинжилгээнд өгнө.	- Төслийн хүрээнд	ҮАЗ-д		2-р улиралд	MNS 4943:2015
Дүн				1.64		

ХӨРСӨН БҮРХЭВЧ, ГАДАРГЫН ХЭЛБЭР ТӨРХӨНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРИЛГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ						
Хөрс эвдрэх, талхлагдах	Уурхайн замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар хийж байрлуулах, ухуулга сурталчилгаа хийх;	-Уурхай ашиглах бэлтгэл үе; -Уурхайн ашиглалтын үе;	1.0	2.0	2-р улиралд	MNS 4597:2013
ШТМ-ын агуулахыг байгуулах үед авах арга хэмжээ	Шатах, тослох материалыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлж орчныг тохижуулах	-Уурхай ашиглах бэлтгэл үе; -уурхайн ашиглалтын үе;	ҮАЗ	ҮАЗ	2-3-р улиралд	MNS 5916:2008
	Автомашин хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах, тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Уурхайн эдэлбэрт болон ашиглалтын талбайн гадна	0,3	2,5		
	Хөрсний бохирдол үүсгэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах;	-Ажиллах нийт хугацаанд: - Тухай бүрт;	ҮАЗ	ҮАЗ	2-3-р улиралд	
Дүн				4.5		
ГАЗРЫН ХЭВЛИЙД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРИЛГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ						
	Олборлолтын улмаас эвдэрсэн газарт жил бүр нөхөн сэргээлтийн ажлыг зохих төлөвлөгөөний дагуу 90	-Ашиглагдсан орон зайд	0.5678	1,5356	2-4-р улиралд	MNS 4597:2013

	хувиас дээш биелэлттэйгээр гүйцэтгэх, жил бүр нөхөн сэргээлтийн ажлыг холбогдох газруудаар дүгнүүлж ажиллах					
Дүн				1.5356		
<b>УРГАМАЛАН НӨМРӨГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРИЛГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ</b>						
Уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр ургамлан нөмрөг устах	Уурхайн хаалтанд зориулж тухайн нутаг орны хөрсөнд зохицсон ургамлын зүйлийн бүрдэлийг ашиглах.	-Ашиглагдсан орон зайд	ҮАЗ-д	ҮАЗ-д	2-4-р улиралд	MNS 49119:2000
Дүн				-		
<b>АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРИЛГАХ ЧИГЛЭЛЭЭР АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ</b>						
Уурхайн үйл ажиллагааны нөлөөгөөр зэрлэг амьтад дайжих, амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх	Уурхай ачиж тээвэрлэх үед тээврийн хэрэгслийн хурд тогтоох, осол гарч болзошгүй мал, амьтан өнгөрөн гардаг хэсгүүдэд тэмдэглэгээ байрлуулах	-Төслийн үйл ажиллагаа явагдаж буй газар нутгийн орчимд	ҮАЗ-д	ҮАЗ-д	2-4-р улиралд	Амьтны аймгийн тухай хууль: 6.1.7
	Ажилчдыг хууль бусаар ан хийхгүй байхыг анхааруулах, сургалтанд хамруулах, хяналт тавих	-Нийт ажилчид	ҮАЗ-д	ҮАЗ-д	3-р улиралд	
Дүн				-		
<b>Нийт дүн</b>				<b>8.4</b>		

## 5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө:

“Уртын хөндий”-ийн алтны шороон орд орчимд газрын гадарга, хөрс, гадаргын усан сүлжээ, ургамлан нөмрөгт үүсэх эвдрэлийг техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн арга хэмжээ авч, нөхөн сэргээх ажлын хэмжээ, холбогдох зардлыг төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журам, аргачлал, стандарт шаардлагын дагуу нарийвчлан тооцох зорилготойгоор энэхүү төлөвлөгөөг боловсруулсан болно.

2024 онд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн хувьд шимт хөрсийг хэлбэржүүлэн, угаан баяжуулах үед эвдэрсэн газрыг тэгшилж, шимт хөрсөөр хучих техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэнэ. Уурхайн олборлолтын үйл ажиллагаа ТЭЗҮ-ийн дагуу явагдаагүй 2024 онд дахин ТЭЗҮ-ийн тодотгол хийгдэж байна. Иймд БОНҮ-д тусгасан 2024 оны нөхөн сэргээлтийн зардалаас зөрөх үндэслэл болж байна. Гэхдээ нэгж талбайн нөхөн сэргээлтийн зардал нь дахин ихээр тусгагдсан болно

2024 онд тус компани нь олборлолтын ажилд хамрагдсан нийт талбайн 40-50 хувьд болон 2023 оны үлдэгдэлтэй нийлээд 3.1 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажил, 2023 онд техникийн нөхөн сэргээлт хийсэн 2.9 га талбайд шимт хөрс тараалтын ажлыг хийнэ гэж төлөвлөгөөнд тусгасан болно. Мөн өмнөх онд техникийн нөхөн сэргээлт хийсэн 2,9 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажлыг тус тус хийхээр төлөвлөсөн.

### Нөхөн сэргээлтийн чиглэлээр хийх арга хэмжээний төлөвлөгөө

№	Зардлын утга	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ	Ашиглагдах техник, тайлбар	Нэгж өртөг мян.төг	Нийт зардал сая.төг	Баримтлах стандарт, аргачлал
Техникийн нөхөн сэргээлт / 3.1 га/ - Бэлтгэл ажлын зардал:							
1	Нөхөн сэргээлтийн ажлын хөрөнгө оруулалтын зардал	Сая.төг				-	
Техникийн нөхөн сэргээлтийн зардал:							
4	Шимт хөрсний үе давхаргын хуулах, ачих, хадгалах	мян.м <sup>3</sup>	2,9	Бульдозер, Экскаватор	0.5	1,45	“Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт,
5	Хөрс тээвэрлэх	мян.м <sup>3</sup>	2,9	Бульдозер, Экскаватор	0.5	1,45	
6	Уурхайн малталтыг дүүргэж, тэгшлэх	мян.м <sup>3</sup>	10.54	Бульдозер, Экскаватор	0.63	6,64	
7	Овоолгын талбайг хэлбэржүүлэн тэгшлэх, нягтаршуулах	мян.м <sup>3</sup>	6.2	Бульдозер, Экскаватор	1,0	6,2	



8	Шимт хөрсөөр талбайг хучих	мян.м <sup>3</sup>	6.2	Бульдозер, Экскаватор	0.5	3,1	Техникийн ерөнхий шаардлага MNS 5917:2008”, 2010.05.17 А-132/112	
9	Тэгшилсэн талбай дээр дэвссэн хөрсний үеийг тэгшлэх	мян.м <sup>3</sup>	3.1	Бульдозер	1	3,1		
10	Овоолгын хажууг хэвгийжүүлэх, дэвсэгжүүлэх	мян.м <sup>3</sup>	0.525	Бульдозер	1	0.525		
11	Туслах байгууламж байгуулахад үүссэн овоолгыг тэгшлэх	мян.м <sup>3</sup>	0.2	Бульдозер, Экскаватор	1	0.2		
12	Ургамалжуулахад бэлтгэн хөрсийг нягтаршуулах	м <sup>2</sup>	2.9	Бульдозер	0,5	1,45		
13	Хөрс боловсруулах, сайжруулах	мян.м <sup>3</sup>	2.9		0.25	0.725		
14	Шимт хөрсийг хадгалах, хамгаалах	мян.м <sup>3</sup>	2.9		0.25	0.725		
Техникийн нөхөн сэргээлтийн ажлын дүн		сая.төг	Σ(4-14)		26,9			
Биологийн нөхөн сэргээлт /2.9 га/ -ийн ажлын зардал								
15	Бүрхэвч ургамал тарих	га	2.9		2500	7,25	Эвдэрсэн газрыг ургамалжуулах MNS 4918:2000, “Мод сөөгний тарьц, Техникийн шаардлага: MNS 6140-2010 4х”	
16	Олон наст ургамалын үр тарьж суулгах	га	2.9		2500	7,25		
17	Ургамлын үр худалдан авах	кг	204		28.6	8.8		
18	Усалгаа, арчилгаа, тордолт хийх	га	2.9		0.65	1.88		
Биологийн нөхөн сэргээлтийн ажлын дүн		сая.төг	Σ(15-18)		25,2			
НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖЛЫН ЗАРДЛЫН НИЙТ ДҮН		сая.төг	Σ <sub>кс</sub> =А+В+С			52,1		

### 5.3. Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө:

Аливаа уул уурхайн хөгжлийн нөлөөллийг зохистой бууруулахын тулд нөлөөллөөс зайлсхийх, нөлөөллийг бууруулах болон нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэхийн хамт үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлагатай.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн зорилго болно.

Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг (сая.төг)	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Биологийн олон янз байдлыг сайжруулах менежментийн арга хэмжээг тодорхойлох	Тус сум нь хээрийн түймрийн эрсдэл өндөртэй бүс нутаг тул хавар намрын хуурайшилт ихтэй үед хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ болон байгалийн давагдашгүй хүчин зүйл тулгарах үед сумын Засаг дарга, иргэд, нөхөрлөлүүдтэй хамтран ажиллах	Төсөл хэрэгжих Норовлин сумын хэмжээнд	ҮАЗ	ҮАЗ	2-3-р улиралд	Хээрийн түймэр нь гэнэтийн аюултай үзэгдэл бөгөөд тухай бүрт иргэд болон нөхөрлөлүүдийн хүсэлтээр түлш болон техникээр хамтран ажиллаад хэвшсэн болно.
2		Уртын булагийн эхийг хамгаалах, хаалт хашлага барьж байгуулах, мал амьтан орж эхийг бохирдуулахаас сэргийлж жил бүр засч сайжруулах	Уртын булагийн эх	2,0	2,0	2-3-р улиралд	
2		“Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны хэмжээ 500 ширхэг нарс мод	Төсөл хэрэгжих Норовлин сум,Жаргалант 4-р баг -500ширхэг	3,8	18,9	2-3-р улиралд	
3		1,0 га талбайд нөхөн сэргээлт хийх	Төсөл хэрэгжих Норовлин сумын хэмжээнд	10,0	10,0	2-3-р улиралд	
<b>Дүн</b>				32,6			

#### 5.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө:

Тусгай зөвшөөрлийн эзэмшлийн бүс нутаг нь тал хээрийн бүсэд хамаарах бөгөөд ойролцоо томоохон хот, суурин газар байхгүй. Харин ордын урд захад Норовлин сумын 1 дүгээр багийн хуучин малын эмчилгээ тэжээлийн цэг байрладаг. Тус ордод хамгийн ойрхон хүн ам төвлөрсөн газар нь улирлын чанартай ажилладаг Салхитын алтны уурхай 10 км зайд, Тохойбулагийн алтны уурхай 11 км зайд, Норовлин сумын төв 50 км зайд байрладаг. Норовлин сумын хүн ам нь голчлон хувиараа мал аж ахуй эрхэлдэг. Зам харилцааны хувьд Хэнтий, Дорнод аймгийн хойд, урд сумууд болон Хэнтий аймаг, Бэрхийн уурхай, Норовлин сумуудыг холбосон сайжруулсан шороон зам нь ордын баруун талаар 25 км зайд өнгөрдөг. Иймд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох асуудал гарахгүй байх бүрэн боломжтой гэж төсөл хэрэгжүүлэгчийн зүгээс үзэж байгаа болно.

#### 5.5. Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө

Ашиглалтын талбайн ойр орчимд ямар нэгэн түүх, археологи олдвор, дурсгалт зүйлс байх ул мөр байхгүй боловч ашиглалтын явцад эдгээр нь илэрсэн тохиолдолд зохих дүрэм журмын дагуу газар шорооны ажлыг нэн даруй зогсоож, зохих газруудад нь мэдэгдэн авран хамгаалах ажиллагааг өөрийн компаний үйл ажиллагааны зардлаас хийлгэнэ.

#### 5.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө:

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, химийн бодисын эрсдэлийн үнэлгээний дүнд тогтоосон аюултай болон хортой химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгана.

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал сая.төг	Нийт зардал сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж, олборлолтын үйл ажиллагаа доголдох, зогсох	Ажилчин нэг бүрийг хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслээр хангах	Нийт ажилчид	25	ХАБЭА зардал		Жил бүр	ХАБЭА
	Ажилчин нэг бүрт ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалсан хор тайлах зорилгоор өдөр бүр нормын сүү, цагаан идээгээр хангах	Нийт ажилчид	25	ҮАЗардлаар		Жил бүр	ХАБЭА
	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах, төлөвлөлтийг хийх, хэрэгжүүлэх	Нийт ажилчид	25	ХАБЭА зардал		Жил бүр	ХАБЭА
Шатах тослох материалын хадгалалт, ашиглалтаас хүний эрүүл мэнд ба хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх	Шатах тослох материалын хор аюулын лавлах мэдээллийн агуулгаар сургалт хийх	Нийт ажилчид	25	ҮАЗардлаар		Төсөл хэрэгжих хугацаанд ажил эхлэхээс өмнө	Химийн хортой ба аюултай бодисын тухай хууль, холбогдох журам, стандарт
	ШТС нь галын өндөр эрсдэлтэй объектод хамаардаг тул галын аюулгүй байдлын зөвшөөрөл, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийг Хэнтий аймгийн Онцгой байдлын албанаас гаргуулах	Төслийн хэмжээнд	1	ҮАЗардлаар		Хуулийн хугацаанд	Галын аюулгүй байдлын тухай хуулийн 6,1 дэх хэсэг

### 5.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Бид 2024 онд хог хаягдлын менежментийг сайжруулах зарчмын хүрээнд дараах хэд хэдэн ажил төлөвлөж хэрэгжилтийг хангаж ажиллана. Үүнд:

- Анхан шатны эх үүсвэр дээр хог хаягдлыг багасгах
- Хаягдал бүтээгдэхүүний дахин ашиглах
- Хаягдал бүтээгдэхүүнийг дахин боловсруулах зах зээлд нийлүүлэх
- Уурхайн үйл ажиллагаанаас гарч буй бүхий л төрлийн дахин ашиглагдах боломжтой хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж зориулалтын сав, тусгайлан бэлдсэн талбайд цуглуулж хураах
- Ангилан ялгаж цуглуулсан хог хаягдлыг хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд халгүйгээр цуглуулах, уурхайн тосгоноос зайлуулах зорилгоор хог хаягдлыг нэгдсэн цэгт эмх цэгцтэй төвлөрүүлэх
- Хог хаягдалтай холбоотой журмуудыг уурхайн нийт ажилчдад таниулах, хог хаягдлыг ангилан ялгах дадал соёлыг хэвшүүлэх сургалтыг тогтмол явуулах
- Ажлын байрны үзлэг шалгалтыг тогтмол хийж, журмуудын хэрэгжилтийг хангаж байгаа байдалд хяналт тавих
- Уурхайн хэмжээнд дахин ашиглагдах хог хаягдлыг ангилан ялгаж, нутгийн иргэдэд тогтмол тогтсон журмын дагуу олгох
- Хоёрдогч түүхий эд дахин боловсруулдаг, бэлтгэдэг, цуглуулдаг, тээвэрлэдэг, зах зээлд нийлүүлдэг иргэд, байгууллага, үйлдвэрүүдэд худалдан борлуулах, нийлүүлэх замаар уурхайн тосгоноос зайлуулах ажлыг гүйцэтгэх
- Хамгийн сүүлд шатааж болох аюулгүй хог хаягдлыг булаах байдлаар устгах

Тус төлөвлөгөөний хүрээнд дараах журмуудыг дагаж мөрдөнө. Үүнд:

- Уурхайн тосгоны хог хаягдлыг хаях, хадгалах, хянах журам
- Уурхайн засварын газрын хог хаягдлын журам
- Дахин ашиглах хог хаягдал нийлүүлэх, тээвэрлэх журам
- Хог хаягдал ачиж цуглуулах, тээвэрлэх болон устгах журам
- Уурхайн тосгоноос дахин ашиглагдах хог хаягдлыг зайлуулах журам

Төслийн ажиллах хоног, ажиллах хүчний тоо болон тоног төхөөрөмжийн тооноос хамааран үүсэх боломжит хог хаягдлын хэмжээ, хадгалалт, нийлүүлэлт, устгалыг дараах хэлбэрээр ангилана.

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1.	Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын нөлөөгөөр хөрс, ус, агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Засварын хатуу, шингэн хог хаягдлыг зориулалтын талбайд ялган цуглуулж уурхайгаас өөрийн компанийн тариа бригад руу зөөж, хүлээлцсэн акт үйлдэх	Ашиглалтын талбай	ҮАЗ	ҮАЗ	3- улиралд 1 удаа	Хог хаягдалын үндэсний хөтөлбөр, Хог хаягдлын тухай хуулийн 11, 14-р зүйл,
		Ахуйн гаралтай хатуу хог хаягдлыг шаардлага хангасан хогийн саванд ангилан ялгаж, түр хогийн цэгт цуглуулж, орон нутгийн тээвэрлэх эрх бүхий байгууллагатай гэрээ хийж нэгдсэн цэг рүү ачуулж, хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлнө.	Ашиглалтын талбай	ҮАЗ	ҮАЗ	3- улиралд 1 удаа	Хог хаягдлын тухай хуулийн 10-р зүйл,
		<ul style="list-style-type: none"> <li>- Уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа нүхэн жорлон болон ариун цэврийн байгууламж, угаадасны нүхийг MNS 5924:2015 стандартын шаардлага хангасан болгох. Мөн сар бүр ариутгаж халдваргүйжүүлж байх.</li> <li>- Жорлонгийн хаягдлын эрх бүхий байгууллагатай гэрээ</li> </ul>	Төслийн хэмжээнд	2.1	2.1	2-3-р улиралд	MNS 5924:2015

		байгуулан, соруулж цэвэрлэнэ. - Уурхайн талбайд био 00 байршуулна.					
			Дүн		2.1		

### 5.8. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (охшх)

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, төсөл хэрэгжих орчинд амьдардаг, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн амьжиргаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамжийг тодорхойлон оруулна. Мөн уг ажлын хэмжээг хэмжих нэгж, нэгжийн үнэ, нийт зардал, баримтлах стандарт, аргазүй, аргачлалыг тусгана.

#### Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг, Сая\төг	Нийт зардал, сая, Төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал	Дээд доод Хязгаар
<b>АГААРЫН ЧАНАР</b>								
1	Агаар дахь тоосжилтын хяналт: Нийт тоос(TSP), PM2.5, PM10 Тоосны уналт	- Элс угаах төхөөрөмжийн орчимд, - Ажилчдын тосгон -Замын хажууд,	-6-р сард - 9-р сард	TSP, SO <sub>x</sub> , NO <sub>x</sub> , CO <sub>x</sub>	0.35	0.35	MNS 4585:2007 MNS:3384:1982 MNS:4048:1988	ЗДХ
			Дүн			<b>0.35</b>		



ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХИ УС								
2	Газрын доорх усны чанар: Гол ионы найрлага: Усны түвшин; pH, өнгө, булингаршил, хуурай үлдэгдэл, эрдэсжилт, нийт хатуулаг	-Тунгаах нуураас - Мониторингийн 2 цооногоос - Уртын булаг	-6-р сард - 9-р сард	-Satellitephone - GPS -Компас -Дижитал фотоаппарат -Нанна усны физик чанарыг (pH, EC, TDS) хэмжих хээрийн хэрэгсэл	0.325	0.65	MNS 3934:1986 MNS 4943:2015 MNS (ISO) 5667-5:2001	ЗДХ
						<b>1.0</b>		
3. ХӨРСӨН БҮРХЭВЧ								
3	Хөрсний бохирдол, ялзмагийн агууламж, pH, давсжилт, чийгшил, NO <sub>3</sub> -N, P <sub>2</sub> O <sub>5</sub> , K <sub>2</sub> O, Ph, нийт азот, нийт фосфор, 1.0 см <sup>3</sup> дэх бактер, эмгэг төрүүлэгч нян	- Нөлөөлөлд өртөөгүй талбай -Нөхөн сэргээлт хийгдсэн талбай -Шимт хөрсний овоолго	-6-р сард - 9-р сард /2 дээж/	Байрлал тогтоох багаж GPS -Компас -Клинометр налуу хэмжигч -Дижитал фотоаппарат -Туузан метр, 50 м урттай -Хатгуур, 50 см урттай г.м	0.24	0.24		ЗДХ
4	Нефть, нефтийн бүтээгдэхүүн, нүүрсустөрөгчид, хар тугалга (Pb) г.м	-Шатахуун ачих, буулгах, машин механизмыг	-9-р сард /1 дээж/	Байрлал тогтоох багаж GPS -Компас	0.24	0.24	MNS5850 : 2008	ЗДХ

	шатахуунаар цэнэглэх талбайн орчимд - Элс угаах төхөөрөмжийн орчимд - Хог хаягдал бохирын цэгийн орчимд		-Клинометр налуу хэмжигч -Дижитал фотоаппарат				
Дүн						<b>0.48</b>	
<b>4. ДУУ ЧИМЭЭ БА ДОРГИО ЧИЧИРГЭЭ</b>							
5	Гадаад орчны дуу, чимээ	-Нийт талбайд -Ил уурхайн орчимд	9-р сар	-Байрлал тогтоох багаж GPS -Компас -Дуу чимээ хэмжигч фотоаппарат	0.05	0.05	MNS4585: 2007
6	Ажлын байрны дуу, чимээ	-Ил уурхайн орчимд -Элс угаах төхөөрөмжийн орчимд	9-р сар	-Байрлал тогтоох багаж GPS -Компас -Дуу чимээ хэмжигч фотоаппарат	0.05	0.05	MNS4585: 2007
Дүн						<b>0.1</b>	
Нийт дүн						<b>1.58</b>	

### 5.9. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

“Дацантрейд” ХХК нь “Уртын хөндий”-н алтны шороон орддоо ирэх 2024 онд БОМТөлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхдээ дараах удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөг барьж ажиллах болно.

#### Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зардал, сая.төг	Хариуцсан албан тушаалтан	Баримтлах стандарт, аргачлал
1	Байгаль орчны асуудлыг удирдлагын түвшний 1 ажилтанд хариуцуулж хяналт тавин ажиллах	Цалингийн сангаас	Компаний захирал	
2	Байгаль орчны аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх,	Гэрээ	Компаний захирал, уурхайн дарга	
4	БОМТөлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлан боловсруулах	ҮАЗ	Байгаль орчны ажилтан	
5	Нийт ажиллагсадд байгаль орчны талаарх сургалт зохион байгуулах	1,5	Байгаль орчны ажилтан	
	Дүн	1,5		

### 5.10. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь:

Уртын хөндийн алтны шороон ордыг ашиглах явцад байгаль орчинд учрах сөрөг нөлөөллөөс зайлс хийх, бууруулах, нөхөн сэргээх арилгах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, түүх соёлын өвийг хамгаалахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган ажилладаг.

Бид 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх мэдээллийг талуудад хуваарийн дагуу тайлагнах төлөвлөгөөтэй байна.

БОМТ хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд		Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, сая.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
Хэнтий аймаг	Байгаль орчны газар	Тайлан хүргүүлэх, ажлын хэсэгт нөхөн сэргээлтээ хүлээлгэн өгөх	БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө	10-р сараас 12 –р сар	0,2	Төслийн талбай, уурхай	
Норовлин сум	Сумын ЗД, БОХХБайцаагч	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр	БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө	10-р сарын 30	0,2	Сумын төв	
Төрийн захиргааны төв байгууллага	БОАЖЯ-ны ХБОБНУГ	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр болон файл хэлбэрээр		10-р сараас 12 –р сар	ҮАЗ	УБ хот	
Дүн					0,4		

#### 6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах үед олон нийтийн оролцоог хангах нь

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоог тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог хууль тогтоомжид заасан хүрээнд аль болох өргөн хангах, тэдэнд ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт болно.

Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран төсөл хэрэгжих орчны байгаль орчин, нийгэм-эдийн засаг, болзошгүй нөлөөллийн бүс дэх оршин суугчдын эрүүл мэндийн байдлын талаарх мэдээлэл, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төслийн техникийн болон эдийн засгийн гол үзүүлэлтүүд, төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, нөлөөллийн цар хүрээ, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээний талаар болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар үнэн зөв, бодит мэдээлэл

бүхий цуврал илтгэл, танилцуулах хуудас, материалыг бэлтгэн тараана. Мөн тайлангийн эх хувийг тэдэнд танилцах боломжоор нь хангана.

**Хүснэгт 1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал**

№	Арга хэмжээ	БОМТ-ий Зардал, мян.төг	БОНУ-ий зардал	Тайлбар
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	8 400.0	8 400.0	
2	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	32 600.0	32 600.0	
3	Нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө / Техник болон биологи/	52 100.0	52 100.0	
3	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-	-	
4	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-	-	
5	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-	-	
6	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	2 100.0	2 100.0	
7	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1 500.0	1 500.0	
8	Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	400.0	400.0	
9	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	1 580.0	1 580.0	
<b>2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал</b>		<b>98 680.0</b>	<b>98 680.0</b>	

“Дацан трейд” ХХК-ийн “Уртын хөндийн алтны шороон ордыг ил аргаар ашиглах төсөл” төслийн үйл ажиллагаанд нөхөн сэргээлтийн ажлыг үйл ажиллагааны зардлаар хэрэгжүүлэх бөгөөд 2024 онд хэрэгжүүлэн ажиллах Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **98 680,0 мян.төг** болж байна.

